



43

Б Н М А У  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1992 оны 07 сарын 25

№ 18

Улаанбаатар хот

Зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн хуулийн 39 дүгээр зүйл, Засгийн газрын 1991 оны 170 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хотын ой, ангийн аж ахуй болон анчдын нийгэмлэгийн төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэж байсан хяналт зохицуулалт, хамгаалалтын үүргийг хотын Байгаль орчны хяналтын газарт хариуцуулж, энэ ажил үүргийг гүйцэтгэж байсан орон тоо, цалингийн санг уул газарт шилжүүлсүгэй.

2. Хотын анчдын нийгэмлэгийн гүйцэтгэж байсан буу, сум хуваарилах, хяналт тавих үүргийг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа хариуцаж байхаар тогтоосугай.

3. Аж ахуйн нэгжийн хуулийн цагуу Хотын ой, ангийн аж ахуйг 1992 оны 2 дугаар сарын 1-нээр тасалбар болгон татан буулгаж Улаанбаатар хотын "Ой, ан компани" /УУГ/ болгон өөрчлөн зохион байгуулсугай.

4. Зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогцуулан хотын Байгаль орчны хяналтын газар, "Ой ан" компанийн дүрмийг хавсралтын цагуу шинэчлэн баталсугай.

5. "Ой ан компани" /УУГ/-ийн дүрмийн санг 600,0 мянган төгрөгөөр баталсугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогцуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 173 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА...  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

Д.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН



44

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1992 оны .18 . тоот тогтоолроо батлав.

**УЛААНБААТАР ХОТЫН БАЙГАЛЬ ОЧИН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл.

1. Улаанбаатар хотын байгаль, орчны хяналтын газар нь байгаль орчныг хамгаалах талаар явуулж байгаа төрийн хяналтын бодлогыг Улаанбаатар хотын нутаг дэвсгэр, ногоон бүсэд хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

2. Газрын үндсэн зорилт нь харьяалах нутаг дэвсгэр дэх байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн БНМАУ-ын хууль тогтоомж, эрх зүйн бэрэмт бичгүүдэд хяналт тавьж хангуулах явдал юм.

3. Газар нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын хууль тогтоомж, энэ дүрам болон хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тогтоол захирамж Байгаль, орчны хяналтын улсын хорооны тогтоол, тушаалыг удирдлага болгоно.

4. Газар нь хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, Байгаль орчны хяналтын хорооны өмнө ажлаа хариуцан тайлагнана.

Газрын даргыг Улаанбаатар хотын чуулганаар батална.

5. Газар нь үүрэг зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар газрын даргад зөвлөх үүрэг бүхий зөвлөлийг байгуулан ажиллуулна.

6. Газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана. Байгаль орчныг хамгаалах талаар газраас гаргасан шийдвэрийг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт албан байгууллага аж ахуйн нэгж, иргэд харьяалалтыг үл харгалзан заавал биелүүлэх үүрэгтэй.

Газар нь тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, албан ёсний гийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Газрын эрх үүрэг.

8. Газар нь доор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/Байгаль орчны улсын хяналтыг Улаанбаатар хотын нутаг дэвсгэр ногоон бүс дотор зохион байгуулж хэрэгжүүлнэ.

б/Улсын болон орон нутгийн чанартай дархан ба нөөц газар байгалийн үзэсгэлэнт, түүхийн дурсгалт газар, ховор амьтан ургамал, үндэсний цогцолбор зэрэг тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийг хамгаалах.

в/Байгаль орчныг хамгаалахад эдийн засгийн арга хөшүүргийг хэрэглэж, байгалийн нөөцийн ашиглалтын төлбөр, хураамж, түүний зарцуулалтанд хяналт тавих.

г/Аж ахуйн үйл ажиллагаа, бусад чиглэлээр байгаль орчинд үзүүлэх ачаалал, нөлөөллийн үндэсний болон олон улсын жишиг, хэм хэмжээг мөрдүүлэх.

д/Улаанбаатар хотын нийгэм эдийн засгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, лагуул хотуулын төлөвлөлт, байршилт сонголт, мөн шинээр өргөтгөн шинэчлэх тоноглох үйлдвэр аж ахуйн нэгжийн барилга байгууламжийн зургийн даалгавар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл экологийн магадлан шинжилгээ хийж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангуулах.

е/Улаанбаатар хотын ногоон бүсийн байгаль орчны төлөв байдлыг тодорхойлох, байгалийн баялгийн нөөц ой ангийн бодлогыг хэрэгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, зохиотой ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж хотын Ардын Хурлын чуулганд гүйцэтгэх захиргааны хуралд оруулан шийдвэрлүүлэх түүний хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

ж/Хотын ногоон бүсийн байгалийн баялаг, ашигт малтмал, ан амьтан, ургамал, газар, ус, ой мод гэх мэт/ түүний нөөц болон орчныг бохирдуулдаг эх үүсвэрийн бүртгэл судалгаа гаргаж байгаль орчныг хамгаалах бодлого боловсруулахад ашиглах.

з/Цацраг идэвхт болон химийн бусад хортой бодис, нефть хий, үйлдвэрлэлийн хаягдлыг тусгайлан хадгалах, булахад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх.

и/Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, улсын даалгавар захиалгат ажлын биелэлтийг хангуулж гүйцэтгэлийг тогтоосон журмаар гаргуулах.

к/Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэлийг өргөн оролцуулж, ардын уламжлалт зан үйлийг хөгжүүлэн дэмжих, хүүхэд залуучууд, хөдөлмөрчдийн экологийн боловсрол, хүмүүжлийг дэвшүүлэх, сурталчлах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.

л/Экологийн магадлан шинжилгээ хийх, нөхөн сэргээх ажлын зураг төсөл зохиох, хураатгсан дагалт баялаг, ангийн олзворыг боловсруулж борлуулах, байгаль хамгаалах талаар төлбөрт сургалт, сурталчилгаа явуулах замаар байгууллагын санхүүгийн бололцоог намагдүүлэх.

м/Газрын шйл ажиллагаатай холбогдсон санхүү, тайлан бүртгэл, материал техникийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх.

Турав. Газар нь доор дурдсан эрх эдэлнэ.

а/Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа улс, хоршоолал, олон нийт, аж ахуйн нэгж, иргэдээс байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зохих журмын дагуу арга хэмжээ авах, буруутай байгууллага аж ахуйн нэгж иргэд /түүний дотор гадаадын болон хамтарсан/ -ийн үйл ажиллагааг тухайн зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, хэрэв бүр мөсөн зогсоох шаардлагатай гэж үзвэл энэ тухай саналаа Байгаль орчны улсын хяналтын хороо, хотын АХ-ын гүйцэтгэл захиргаанд тавьж шийдвэрлүүлэх.

б/Байгаль орчны байцлыг үнэлэх, хамгаалах тодорхой асуудлаар магадлагаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээ баримт, судалгааг холбогдох байгууллага хүмүүсээс гаргуулж авах.

в/Хот лүүргийн төр, захиргааны болон улс, хоршоолал, олон нийт аж ахуйн нэгж / түүний дотор гадаадын болон хамтарсан байгууллагаас гаргасан шийдвэр/ тогтоол, тушаал, захирамж, заавар, журам, аргачлал техник технологийн шийд нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжинд нийцэхгүй, байгальд сөрөг нөлөө үзүүлэхээр байвал түүнийг заалтыг хүчингүй болгуулах буюу өөрчлүүлэх тухай шаардах, дээд байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх.

г/Хотын нутаг дэвсгэр байгалийн нөөц баялгийг ашиглах, экологийн тэнцвэрийг хадгалах талаар санал дүгнэлтээ Байгаль орчин хяналтын улсын хороо, хотын Ардын Хурлын гүйцэтгэл захиргаанд тавих.

д/Хотын ногоон бүсэд аялал зугаалга хийх, байгалийн дагалт баялгийг түүх ашиглах, загас барих зөвшөөрөл олгохоос гадна зөвшөөрөлгүй бэлтгэсэн мод болон байгалийн бусад дагалт баялаг, ангийн холбогдол бүхий багаж хэрэгсэл, арьс бүтээгдэхүүнийг хураан авч тогтоосон журмын дагуу борлуулах, шилжүүлэх.

е/Байгалийн баялаг ашигласны төлбөр, хураамжаас хотын төсөвт орсон орлогыг байгаль хамгаалах арга хэмжээнд зориулан зарцуулах талаар БӨХУ хороо, хотын АХТЗ-нд санал тавьж шийдвэрлүүлэх.

ё/Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн үзлэг шалгалт, илэрсэн зөрчил цутагдалтай холбогдсон зураг авах, бичлэг хийх, шаардлагатай бол түүнийг нийтийн мэдээллийн хэрэгсэлдээр сурталчлах.

47

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүй-  
цэтгэх захиргааны 1992 оны . 18. тоот  
тогтоолээр батлав.

УЛААНБААТАР ХОТЫН "ОЙ АН КОМПАНИ"  
/УУГ/ ЗИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1. "Ой ан компани" /УУГ/ нь БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн хуулийн дагуу Төрийн өмчин дээр тулгуурлан сайн дурхи үндсэн дээр нэгдэн энэхүү дүрмээр тогтоогдсон эрх үүрэг, хариуцлагаа удирдлага болгон зохион байгуулалт хувиарлалтын зарчмын үндсэн дээр бие даасан дүрмийн сантай тайлан тэнцэлтэй хуулийн этгээд байна.

2. Компаний албан ёсны нэрийг Улаанбаатар "Ой ан компани" /УУГ/ гэж нэрлэнэ. Компани нь тогтоогдсон журмаар хийгдсэн тамга, тэмдэг, албан хэргийн хэвлэмэл хуудас хараглана.

3. Компаний үйл ажиллагааны үндсэн зорилго нь улс нийгэм, гишүүдийнхээ эрх ашиг, хариуцлагыг зохистой хослуулан улс орны эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, ой, ангийн нөөц, баялгийг өсгөн арвижуулахад чиглэгдэнэ.

4. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд тус компани нь дараах чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээнийхээ ажлыг эрхлэн явуулна. Үүнд:

-Ой, ангийн баялгийг үйлдвэрлэлийн аргаар бэлтгэж боловсруулаад, бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэр цех байгуулж ажиллуулах.

-Ой, ангийн гаралтай бүтээгдэхүүний зах, зээл, эрэлт хэрэгцээ үнийн талаар тогтмол судалгаа явуулж гадаад дотоодын зах зээлд борлуулах.

-Үйлдвэрлэл худалдааны ажлыг бие даан болон /аж ахуйн нэгж/ пүүс хоршоолол, компанитай хоршин эрхлэх.

-Ой, ангийн болон байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг гадаад дотоодын байгууллагууд хамтран боловсруулах, экологийн ач холбогдлыг сурталчлах.

-Ой жуулалт ойн аж ахуйн арга хэмжээг улсын захиалга, дэвлгаварын дагуу улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэнэ.

-Ан амьтныг өсгөн үржүүлэх нутагшуулах замаар экологийн тэнцвэрт нөлөөлөхгүйгээр үйлдвэрлэл явуулах.

## 2.

5.Компани нь Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны тогтоол гарч, санхүүгийн халтзот бүртгүүлж гэрчилгээ авсан өдрөөс ахлан үйл ажиллагаагаа явуулна.

6.Компаний гишүүнээр гадаад дотоодын сонирхсон байгууллага, пүүс хоршоо, компани, хувь хүмүүс элсэн орж болно.

Хоёр.Компаний дүрмийн сан,  
ашгийн хуваарилалт

1.Компаний өмч хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн бусад эд хөрөнгөөс бүрдэнэ.

2.Компани хэвийн үйл ажиллагаат хангахын тулд дүрмийн санг 600 мянган төгрөгөөр тогтоож гишүүдээс мөнгөн ба биет зүйлээр оруулах хөрөнгөөр байгуулна.

3.Компани цэвэр ашгийг дараах журмаар хувиарлана.

а/Жил бүрийн цэвэр ашгийн дүнгээс <sup>дүрмийн</sup> сангийн 5 хувьтай тэнцэх хэмжээгээр болож нөөц санд төвлөрүүлнэ. Нөөц санд шимтгэх хөрөнгийн хэмжээ цэвэр ашгийн . . . хэвцэс доошгүй байна.

4.Компаний алдагдлыг нөөц сангаараа нөхнө. Харэв нөөц сангийн хөрөнгө хураахгүй бол гишүүдийн хурлаар хэлэлцэж нэмэлт хөрөнгө гаргуулан нөхнө.

Гурав.Компаний гишүүдийн эрх үүрэг.

1.Компаний гишүүд нь хувь хөрөнгөө сайн дурын үндсэн дээр компаний мэдээлд оруулах.

2.Гишүүд нь үйлдвэрлэгч байхын дээр хувь хун, компани хоёрын ашиг сонирхолд нийцсэн арилжаа эрхэлж болно.

3.Гэрээгээр хүдээсэн үүргээ удаа дараа биелүүлдэггүй гишүүнийг компаниас хална.

4.Гишүүнээс халах шалтгааныг тухайн гишүүнд мэдэгдэнэ. Гишүүнээс гарах тухай асууцлыг хэлэлцэж шийдвэрлэхэд тухайн гишүүн санал өгөх эрхтэй байна.

5.Халагдсан гишүүн халах шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн шийдвэр авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд томдол гаргах эрхтэй.

6.Компаний гишүүд нь хөдөлмөрийн гаргаа байгуулж ажиллана.

Дөрөв. Угирдлага зохион байгуулалт  
бүтэц

1. Компаний эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал бөгөөд түүний чөлөөт цагт компаний үйл ажиллагааг захирал явуулна.

2. Бүх гишүүдийнхурлаар хэлэлцэх асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Харин санал хураалтын тоо тэнцсэн үед эцсийн шийдвэрийг захирал гаргана.

3. Компаний цаг үеийн шуурхай асуудлыг шийдвэрлэхэд инженер менежерүүдээс бүрдсэн ажлын хэсэг зохион байгуулж ажиллуулна.

4. Бүх гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Дор дурдсан асуудлыг эгзэвэл бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

а/Тайлан тэнцэл ажил хувиарлах

б/Гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах.

в/Захирлыг сонгох, чөлөөлөх, түүнд олгох цалин хөлсийг тогтоох.

г/Хяналтын зөвлөлийг сонгох, чөлөөлөх олгох цалин хөлс тогтоох.

д/Компанийг өөрчлөх /нийлүүлэх нэгтгэх, салгах/ үйл ажиллагааг нь зогсоох.

ж/Гэрээ, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах.

з/Гэрээнд заасан бусад зүйл.

5. Бүх гишүүдийн хурлаас захирлыг 3-5 жилийн хугацаагаар сонгож ажиллуулна.

6. Захирал дор дурьдсан эрх элэлж үүрэг хүлээнэ.

а/Компаний өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

б/Бүх гишүүдийн хуралд ажлаа тайлаглана.

в/Тухайн компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчидтай компанийг төлөөлж гэрээ хийнэ.

г/Тайлан тэнцэл болон компаний эд хөрөнгийн талвархи мэдээ тайланг хариуцна. Үйл ажиллагааныхаа талаар байнга мэдээллээр хангана.

д/Компаниас гарсан мэдээ тайлангийн үнэн зөвийг хариуцна.

Тав. Компаний хяналтын зөвлөл санхүүгийн хяналт  
шалгалт эцсийн тооцоо хийх татан буулгах.

1. Компаний хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр

## 4.

компаний удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор бүх гишүүдийн хурлаас сонгон ажиллуулна.

2. Компаний санхүүгийн үйл ажиллагааг БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу Улсын санхүүгийн байгууллагаас хянан шалгана.

3. Компаний санхүү аж ахуйн үйл ажиллагаанд мэргэжлийн дүн шинжилгээ, хяналт шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн байцаагчийг гэрээгээр ажиллуулж болно.

4. Хөндлөнгийн байцаагч нь БНМАУ-ын аж ахуйн нэгжийн хуульд заасан эрх, үүрэг авална.

5. Компаний үйл ажиллагааг дор дурдсан үндэслэлээр зогсоож болно.

а/Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр.

б/Өөр этгээдэд эрхээ шилжүүлэхгүйгээр компаний үйл ажиллагааг зогсоохоор шийдвэрлэсэн.

в/Шүүхийн шийдвэрээр

г/Хуульд заасан бусад үндэслэлээр

6. Үйл ажиллагаагаа зогсоосон нөхцөлд Компаний зүсийн тооцоо хийнэ. Уг ажилд компаний удирдлага гүйцэтгэнэ. Үүнд:

-Зүсийн тооцоо хийж байгаа тухай банк болон сонирхогч этгээдэд мэдэгдэнэ.

-Дуусгалын тайлан тэнцэл гаргаж бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж батлана.

-Зүсийн тооцоо хийж дуусгасныг бүртгэх байгууллагад мэдэгдэж тухайн компанийг улсын бүртгэлээс хасуулах тухай хүсэлт гаргана.

-Зүсийн тооцоо хийж байгаа этгээд гишүүний хооронд үүсэх маргааныг шүүх шийдвэрлэнэ.